



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/91/-НА-СТА-ТШЗ
ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/131
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.БАТЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
19020417

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,920,667.24	71,960,389.67
33	АВЛАГА	9,996,752.00	21,663,470.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	931,970.00	931,970.00
335	Бусад авлага	9,064,782.00	20,731,500.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	20,681,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,064,782.00	50,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,923,915.24	50,296,919.67
351	Түүхий эд материал	561,700.00	561,700.00
35110	Тусгай зориулалттай материал	561,700.00	561,700.00
354	Хангамжийн материал	44,362,215.24	49,735,219.67
35410	Бичиг хэргийн материал	2,996,500.00	7,161,500.00
35420	Аж ахуйн материал	28,553,379.67	27,366,379.67
35440	Түлш, шатах тослох материал	115.57	00.00
35470	Бусад хангамжийн материал	12,812,220.00	15,207,340.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,745,052,652.30	10,645,451,372.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,745,052,652.30	10,645,451,372.19
392	Биет хөрөнгө	10,674,760,152.30	10,563,241,372.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,481,960,029.23	12,922,221,635.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,068,092,733.15	-2,887,352,527.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	297,972,766.00	256,972,766.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-227,405,939.39	-205,404,899.43
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	134,456,349.10	150,427,949.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,735,952.53	-85,273,559.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	126,755,538.25	118,451,064.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-61,612,683.11	-73,734,278.56
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,900,000.00	3,900,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	100,482,074.00	416,321,692.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-35,919,296.10	-53,288,468.49
393	Биет бус хөрөнгө	70,292,500.00	82,210,000.00
39301	Програм хангамж	785,000.00	785,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-785,000.00	-785,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	70,870,000.00	82,870,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-577,500.00	-660,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,799,973,319.54	10,717,411,761.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,014,782.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,014,782.00	00.00
413	Өглөг	9,014,782.00	00.00
4136	Бусад өглөг	9,014,782.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,014,782.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,790,958,537.54	10,717,411,761.86
51	Засгийн газрын хувь оролцоо	10,790,958,537.54	10,717,411,761.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	613,627,732.74	613,627,732.74
51101	Өмч: - төрийн	613,627,732.74	613,627,732.74
512	Хуримтлагдсан үр дүн	5,836,382,499.50	5,752,859,947.08
51210	Өмнөх үеийн үр дүн	5,836,382,499.50	5,836,406,722.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-73,546,775.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,340,948,305.30	4,340,924,082.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,799,973,319.54	10,717,411,761.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,885,530,476.60	2,000,837,043.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	872,161,363.60	703,070,727.00
120	Нийтлэг татварын бус орлого	872,161,363.60	703,070,727.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	872,161,363.60	703,070,727.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	872,161,363.60	703,070,727.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,013,369,113.00	1,297,766,316.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,546,613.00	115,695,916.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	7,003,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,819,697.00	37,741,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,261,716.00	29,110,790.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,465,200.00	41,841,126.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	947,822,500.00	1,182,070,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	947,822,500.00	1,182,070,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,626,311,222.98	2,016,411,670.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,578,353,709.06	1,957,137,637.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,546,576,375.02	1,929,779,011.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,443,817.70	603,547,272.65
210101	Үндсэн цалин	292,452,524.71	278,908,435.24
210102	Нэмэгдэл	88,930,017.57	103,237,931.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,218,151.00	28,498,664.81
210104	Урамшуулал	86,821,223.82	101,110,634.90
210105	Гэрээт ажлын хөлс	69,021,900.60	91,791,606.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,539,833.49	78,478,905.10
210201	Тэтгэврийн даатгал	49,377,047.23	55,638,877.87
210202	Тэтгэмжийн даатгал	6,538,572.47	6,127,873.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,193,113.28	4,851,898.65
210204	Ажилгүйдлийн даатгал	335,325.00	1,071,378.43
210205	Эрүүл мэндийн даатгал	8,095,775.52	10,788,876.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,083,886.50	170,403,093.40
210301	Гэрэл, цахилгаан	31,579,812.00	31,563,100.00
210302	Тулш, халаалт	126,067,128.50	126,067,153.40
210303	Цэвэр, бохир ус	7,436,946.00	12,772,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,929,916.37	33,989,322.36
210401	Бичиг хэрэг	9,145,600.00	10,379,500.00
210402	Тээвэр, цатахуун	10,023,123.83	13,752,095.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,452,038.00	9,482,327.19
210404	Ном, хэвлэл	345,000.00	375,400.00
210408	Бараа материал акталсны зардал	10,964,154.54	00.00
2105	Нормативт зардал	4,054,060.00	5,001,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,054,060.00	5,001,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,531,840.00	7,388,934.00
210601	Багаж, техник хэрэгсэл	387,000.00	1,014,200.00
210604	Урсгал засвар	3,144,840.00	6,374,734.00
2107	Томилолт, зочны зардал	960,000.00	2,580,000.00
210702	Дотоод албан томилолт	960,000.00	2,580,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,261,488.35	12,612,673.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	15,665,984.35	10,186,963.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,450,000.00	1,248,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	530,640.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	394,864.00	491,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	202,000.00	180,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	18,000.00	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	698,771,532.61	1,015,777,810.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,931,931.00	122,970,114.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	650,839,601.61	892,807,695.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,777,334.04	27,358,625.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,995,000.00	4,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,995,000.00	4,900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,782,334.04	22,458,625.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,782,334.04	22,458,625.61
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,957,513.93	59,274,033.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,957,513.93	59,274,033.00
221001	Их засвар	00.00	517,043.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	18,000,000.00
223001	Бусад хөрөнгө	47,957,513.93	40,756,990.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	259,219,253.62	-15,574,627.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	81,159,408.31	57,972,148.22
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	69,621,472.71	7,585,608.22
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	11,537,935.60	50,386,540.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-81,159,408.31	-57,972,148.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	178,059,845.31	-73,546,775.68

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,627,732.74	4,340,985,064.89	5,658,285,894.60	00.00	10,612,898,692.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	36,709.59	00.00	36,709.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	613,627,732.74	4,340,985,064.89	5,658,322,604.19	00.00	10,612,935,401.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	178,059,845.31	00.00	178,059,845.31
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,627,732.74	4,340,948,305.30	5,836,382,499.50	00.00	10,790,958,537.54
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	613,627,732.74	4,340,948,305.30	5,836,382,499.50	00.00	10,790,958,537.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	24,223.26	00.00	24,223.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	613,627,732.74	4,340,948,305.30	5,836,406,722.76	00.00	10,790,982,760.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-24,223.26	00.00	00.00	-24,223.26
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-73,546,775.68	00.00	-73,546,775.68
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,627,732.74	4,340,924,082.05	5,762,859,947.08	00.00	10,717,411,761.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,013,369,113.00	1,297,766,316.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,013,369,113.00	1,297,766,316.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,546,613.00	115,695,916.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	7,003,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ,хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,819,697.00	37,741,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,261,716.00	29,110,790.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,465,200.00	41,841,126.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	947,822,500.00	1,182,070,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	947,822,500.00	1,182,070,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	928,160,358.22	1,068,957,707.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	928,160,358.22	1,068,957,707.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	896,383,024.18	1,041,599,081.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,443,817.70	606,855,100.00
210101	Үндсэн цалин	292,452,524.71	283,384,669.98
210102	Нэмэгдэл	88,930,017.57	100,071,005.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,218,151.00	30,428,318.11
210104	Урамшуулал	86,821,223.82	101,514,917.85
210105	Гэрээт ажлын хөлс	69,021,900.60	91,456,188.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,539,833.48	75,856,600.00
210201	Тэтгэврийн даатгал	49,377,047.22	51,582,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,538,572.46	6,068,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,193,113.28	4,854,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	335,325.00	1,213,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,095,775.52	12,137,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,707,900.00	170,403,068.00
210301	Гэрэл, цахилгаан	31,203,825.50	31,563,100.00
210302	Түлш, халаалт	126,067,128.50	126,067,128.00
210303	Цэвэр, бохир ус	7,436,946.00	12,772,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,622,248.00	33,436,013.19
210401	Бичиг хэрэг	9,000,000.00	10,190,900.00
210402	Тээвэр, шатахуун	8,870,210.00	13,262,786.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,352,038.00	9,482,327.19
210404	Ном, хэвлэл	400,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	3,300,000.00	5,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,300,000.00	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,894,110.00	8,881,034.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,140,410.00	1,376,034.00
210604	Урсгал засвар	3,753,700.00	7,505,000.00
2107	Томилголт, зочны зардал	960,000.00	2,580,000.00
210702	Дотоод албан томилолт	960,000.00	2,580,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,115,587.50	11,859,051.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,520,083.50	9,433,341.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,450,000.00	1,248,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	394,864.00	491,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	202,000.00	180,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,640.00	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,799,527.50	126,728,215.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,799,527.50	126,546,215.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	182,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,777,334.04	27,358,625.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,995,000.00	4,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,995,000.00	4,900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,782,334.04	22,458,625.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,782,334.04	22,458,625.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	85,208,754.78	228,808,609.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	85,208,754.78	228,808,609.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,208,754.78	228,808,609.00
2200	Дотоод эх үүсвэрээр	85,208,754.78	228,808,609.00
221001	Их засвар	00.00	517,043.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	36,500,000.00
223001	Бусад хөрөнгө	48,247,314.78	44,966,229.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,961,440.00	146,825,337.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-85,208,754.78	-228,808,609.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	947,822,500.00	918,083,784.46	1,182,070,400.00	1,159,613,920.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,088,500.00	851,384,319.68	992,420,400.00	980,829,534.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	879,088,500.00	849,389,319.68	990,420,400.00	978,829,534.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	567,450,300.00	548,443,817.70	606,855,100.00	606,855,100.00
210101	Үндсэн цалин	292,583,700.00	292,452,524.71	292,583,700.00	283,384,669.98
210102	Нэмэгдэл	78,402,600.00	88,930,017.57	78,402,600.00	100,071,005.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,755,200.00	11,218,151.00	49,760,000.00	30,428,318.11
210104	Урамшуулал	95,760,000.00	86,821,223.82	95,760,000.00	101,514,917.85
210105	Гэрээт ажлын хөлс	81,948,800.00	69,021,900.60	90,348,800.00	91,456,188.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,605,800.00	68,539,833.48	75,856,600.00	75,856,600.00
210201	Тэтгэврийн даатгал	76,605,800.00	49,377,047.22	51,582,600.00	51,582,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	6,538,572.46	6,068,500.00	6,068,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,193,113.28	4,854,800.00	4,854,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	335,325.00	1,213,600.00	1,213,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	8,095,775.52	12,137,100.00	12,137,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,508,000.00	164,707,900.00	176,507,900.00	170,403,068.00
210301	Гэрэл, цахилгаан	9,197,100.00	31,203,825.50	12,197,100.00	31,563,100.00
210302	Тулш, халаалт	164,134,500.00	126,067,128.50	159,134,500.00	126,067,128.00
210303	Цэвэр, бохир ус	3,176,400.00	7,436,946.00	5,176,300.00	12,772,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,701,100.00	26,122,248.00	26,167,900.00	26,148,957.19
210401	Бичиг хэрэг	8,500,000.00	8,500,000.00	9,367,900.00	9,367,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,887,200.00	8,870,210.00	6,800,000.00	6,798,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,913,900.00	8,352,038.00	9,500,000.00	9,482,327.19
210404	Ном, хэвлэл	400,000.00	400,000.00	500,000.00	500,000.00
2105	Норматив зардал	3,000,000.00	3,300,000.00	5,000,000.00	5,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	3,300,000.00	5,000,000.00	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	17,160,700.00	11,000,000.00	11,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	14,000,000.00	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	3,160,700.00	7,000,000.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,148,300.00	744,000.00	400,600.00	384,000.00
210702	Дотоод албан томилолт	2,148,300.00	744,000.00	400,600.00	384,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,050,000.00	7,595,504.00	2,484,700.00	2,425,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,450,000.00	1,450,000.00	1,248,000.00	1,248,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	394,864.00	550,000.00	491,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	202,000.00	180,700.00	180,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	48,640.00	6,000.00	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,625,000.00	12,775,316.50	86,147,600.00	80,756,099.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,625,000.00	12,775,316.50	86,147,600.00	80,756,099.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	1,995,000.00	2,000,000.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,995,000.00	2,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,995,000.00	2,000,000.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,734,000.00	66,699,464.78	189,650,000.00	178,784,386.00
2200	Дотоод эх үүсвэрээр	66,734,000.00	66,699,464.78	189,650,000.00	178,784,386.00
221001	Их засвар	-	-	67,400,000.00	63,932,335.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	75,000,000.00	69,885,822.00
223001	Бусад хөрөнгө	66,734,000.00	66,699,464.78	47,250,000.00	44,966,229.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	947,822,500.00	918,083,784.46	1,182,070,400.00	1,159,613,920.76
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	947,822,500.00	918,083,784.46	1,182,070,400.00	1,159,613,920.76
132001	Орон нутгийн төсвөөс	947,822,500.00	918,083,784.46	1,182,070,400.00	1,159,613,920.76
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48	48	48	48
620001	Удирдах ажилтан	09	09	09	09
620002	Гүйцэтгэх ажилтан	24	24	24	24
620003	Үйлчлэх ажилтан	15	15	15	15

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,502,994.50	115,693,769.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,502,994.50	115,693,769.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,502,994.50	112,793,769.63
2104	Хангамж, бараа материалын зардал	500,000.00	7,287,056.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	823,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	6,464,056.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	593,000.00	505,000.00
210604	Урсгал засвар	593,000.00	505,000.00
2107	Томилолт, зочны зардал	216,000.00	2,196,000.00
210702	Дотоод албан томилолт	216,000.00	2,196,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,520,083.50	9,433,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,520,083.50	9,433,341.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,673,911.00	93,372,372.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,673,911.00	93,190,372.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	182,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,900,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,546,613.00	115,695,916.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,546,613.00	115,695,916.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	7,003,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,894,697.00	37,741,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,186,716.00	29,110,790.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,465,200.00	41,841,126.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийн гүйцэтгэл, өр, авлага, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар нь оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар иргэдийнхээ сайн сайхны төлөө тэдний амьдралын чанарыг байнга дээшлүүлэх боломжоор хангаж сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх төрийн захиргааны байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын багийг 2021 оны 11 дүгээр сарын 15-нд Засаг даргын А/401 тоот захирамжаар шинэчлэн байгуулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор хяналт шинжилгээ үнэлгээний журам шинэчлэн боловсруулж, ажилдаа мөрдлөг болгон ажилласан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,885,530.5 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 18,855.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,198.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 20,008.4 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 1,153.1 мянган төгрөгөөр нэмэгдэж зөрүү бага тул материаллаг түвшинг дахин тооцох шаардлагагүй гэж үзэв.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт орлого 1,885,530.5 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны орлого 2,000,837.0 мянган төгрөг, 115,306.5 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Зуунмод сумын Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 1,182,070.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 703,070.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 115,695.9 мянган төгрөг нийт 2,000,837.0 мянган төгрөг өмнөх оноос 115,306.5 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар нэмэгдсэн байна.

Зардал :

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 2,026,411.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,068,957.7 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 980,829.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100142255001 тоот дансанд 2021 онд 1,182,070.4 мянган төгрөгийн орлого, 1,182,070.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 100142255408 тоот дансанд 115,695.9 мянган төгрөгийн орлого, 115,695.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	9,996.7	21,663.5	-11,666.8
Урьдчилгаа			
Бараа материал	44,923.9	50,296.9	-5,373.0
Үндсэн хөрөнгө	10745,052.7	10,645,451.4	99,601.3
Нийт хөрөнгө	10,799,973.3	10,717,411.8	82,561.5
Өр төлбөр	9,014.8		9,014.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,790,958.5	10,717,411.8	73,546.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,799,973.3	10,717,411.8	82,561.5

Авлага дансны оны эхний үлдэгдэл 9,996.7 мянган төгрөгийг барагдуулж, оны эцсийн үлдэгдэл 21,663.5 мянган төгрөг нь Одонт хөтлийн явган замын санхүүжилт, малын тэжээл, Зуунмод хотын өндөрлөгийн зургийн санхүүжилт олгосон мөнгөөр авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 50,296.9 мянган төгрөг болж 5,373.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хандиваар ирсэн бараа материалаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,645,451.4 мянган төгрөг болж 99,601.3 мянган төгрөгөөр буурсан нь акталсан хөрөнгө болон элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй болон шилжүүлэн авсан 703,070.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар худалдан авсан 146,825.3 мянган төгрөгийн

хөрөнгөөр нэмэгдэж акталж устгасан 66,023.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,707,411.8 мянган төгрөг болж 83,645.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,149,305.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,149,305.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 35,882.2 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 1,113,422.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр Зуунмод сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан байна.

Тус байгууллагын төсвийг Зуунмод сумын ИТХ-ын 2021 оны 10 дүгээр сарын 6-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 1,182,070.4 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,182,070.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,182,070.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,182,070.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,159,613.9 мянган төгрөгийг зарцуулж, 22,456.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,159,613.9 мянган төгрөг буюу 97.59 хувьтай байгаа нь 22,456.5 мянган төгрөг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хандиваар 7,003.0 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 66,851.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 41,841.1 мянган төгрөг нийт 115,695.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар хангамжийн зардал 7,287.1 мянган төгрөг, эд хогшлын зардал 505.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 2,196.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж 9,433.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 93,372.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2,900.0 мянган төгрөг зарцуулж, 2.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Баянхошуу багийн байрны гадна хашааны санхүүжилтэд 8,350.0 мянган төгрөг, явган зам, дугуйн зам, Ланс багийн явган хүний гүүрний засварын санхүүжилтэд 28,567.5 мянган төгрөг, Номт болон Баруун Зуунмод багийн тоглоомын талбайн санхүүжилтэд 27,014.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Ланс, Зүүндэлгэр багийн гэрэлтүүлэг, усан санг цахимжуулахад 28,855.7 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 4,530.0 мянган төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ковидтой холбоотой зардалд 8,000.0 мянган төгрөг, Одонт хөтлийн явган замын ажилд 5,000.0 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлэгт 3,500.0 мянган төгрөг, Зуунмод сумын Өндөрлөгийн зургийн ажлын санхүүжилтэд 10,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Ланс, Баянхошуу, Зүүндэлгэр багийн автобусны нөхөн олговор болон бусад хөрөнгөнд 44,866.2 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Ковид-19 цар тахалд 7,518.0 мянган төгрөг, түргэвчилсэн оношлуурын 21,448.0 мянган төгрөг орлого бүрдүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд төсвийн хөрөнгө оруулалтаар 28,702.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 114,134.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 3,988.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд 369,455.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 157,454.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 12,000.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/403 тоот захирамжаар “Зуунмод хотын 80 жил”-ийн ойг угтан өндөрлөгийн ажлын зураг, төсвийг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар байгуулагдсан ажлын хэсэг ХБХДТ ХХК-ийг шалгаруулсан байна.

Тус байгууллага тайлант онд “ЗУУНМОД ХОТЫН ӨНДӨРЛӨГ”-ийн ажлын зураг төсөв гүйцэтгэх №ТӨАЗМЗСДТГ/2021011036 тоот гэрээг ХБХДТ ХХК-тай 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна. Тус байгууллага зарлагын 32 гүйлгээ, 5,0 саяас дээших худалдан авалтын 18 гүйлгээ хугацаанд байршуулж, 5,0 саяас дээших орлогын 14 гүйлгээ байршуулахаас 40,169.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага тайлант онд Коронавируст халдвар цар тахалтай холбогдуулан 7,518.0 мянган төгрөгийн хандивын мөнгийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандивыг Улсын онцгой комисс болон холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, зарцуулалтыг олон нийтэд ил тод байлгаж, нэн шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд авч тайлагнасан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй 1 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 02/870 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 126,476.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 10,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 59,511.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 56,964.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

4.2.1 Залруулсан алдаа

Тус байгууллага тайлант онд Зуунмод өндөрлөгийн зураг төсвийн санхүүжилтийн 10,000.0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.3 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 44,364.7 мянган төгрөгийн 23 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.7 дах заалтыг Ирмүүн эрхэс ХХК-д бүтээн байгуулалтын ажлын видео контетийн зардалд 2,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3.Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.3 дах заалтыг зөрчин Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн Б/55 тоот тушаалаар сумын Засаг даргын үндсэн цалинг, сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны А/409 тоот захирамжаар Засаг даргын Тамгын газрын даргын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн нийт 3,146.8 мянган төгрөгийн шагналт цалин олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.3-д “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.Тус байгууллага тайлант онд “ЗУУНМОД ХОТЫН ӨНДӨРЛӨГ”-ийн ажлын зураг төсөв гүйцэтгэх №ТӨАЗМЗСДТГ/2021011036 тоот гэрээг ХБХДТ ХХК-тай 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан байна. Гэтэл хавсаргасан өнгөт зургийн төслийн ХБХДТ 01/2022 дугаартай, ажлын зураг төсөв байхгүй, гэрээ дүгнэсэн актыг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр үйлдэн, санхүүжилтийг гэрээ байгуулснаас хойш 3 хоногийн дараа ХБХДТ ХХК-д 10,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 тоот тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.12-д “төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно”, 17 дугаар зүйлийн 17.1-д “энэхүү журмыг хэрэгжүүлэх албан тушаалтан, мэргэжилтэн, нь чиг үүргээ төсвийн сахилга бат, мэргэжлийн ёс зүйг баримтлан, хууль ёсны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус бие даан гүйцэтгэх ба тухайн этгээдийн хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно”, Төв аймгийн “Зуунмод хотын өндөрлөг”-ийн ажлын зураг төсөв гүйцэтгэх ТӨАЗМЗСДТГ/2021011036 гэрээний 2 дугаар заалтын 2.3-т “уг ажлын гүйцэтгэлээр 100 хувь санхүүжилтийг олгоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Өр,авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд оны эхний үлдэгдэл 931.9 мянган төгрөг, 2 байгууллагаас 20,681.5 мянган төгрөг, хувь хүнээс 50.0 мянган төгрөг нийт 21,663.4 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

2.Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг зөрчин Зуунмод хотын 80 жилийн ой, өдрийг угтаж танилцуулга номонд 4,000.0 мянган төгрөг Ирмүүн эрхэс ХХК-д шилжүүлсэн, дэвтэр бал үзгийн зардалд 315.0 мянган төгрөг, цэрэг татлагын хоол, материалын зардалд 816.9 мянган төгрөг нийт 5,131.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

3.Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна.Тус байгууллага зарлагын 32 гүйлгээ, 5,0 саяас дээших худалдан авалтын 18 гүйлгээ хугацаанд байршуулж, 5,0 саяас дээших орлогын 14 гүйлгээ байршуулахаас 40,169.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	ЗДТГ	6	86,307.1	0	10,000.0			4	59,511.5	2	16,795.6
	Дүн	6	86,307.1	0	10,000.0			4	59,511.5	2	16,795.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		1	40,169.0							1	40,169.0
	Дүн	1	40,169.0							1	40,169.0
	Нийт дүн	7	126,476.1	0	10,000.0	0	0	4	59,511.5	3	56,964.6

